

178



ГОВЬСҮМБЭР АЙМАГ  
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 07 сарын 02 өдөр

Дугаар А/87

Шивээговь сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1, 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 28 дугаар зүйлийн 28.7.2, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.3, Шивээговь сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2023 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн хуралдааны 06 дугаар “Сумын 2024 оны төсөв батлах тухай” тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:


1. Улс орон ус цаг уурын аюулт үзэгдэл ихээр үүсч байгаатай холбоотой Гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах арга хэмжээний хүрээнд Орон нутгийн хөгжлийн сангийн Гамшгийн зардлын хөрөнгөөр Сумын Онцгой комисс, Шуурхай штаб, Мэргэжлийн ангийн бие бүрэлдэхүүнд шаардлагатай тоног төхөөрөмж худалдан авах, тохижилтын ажилд 5,000,000 (таван сая) төгрөгийг зарцуулсугай.
2. Дээрх ажилд шаардлагатай тоног төхөөрөмж худалдан авах, тохижилтын ажилд зарцуулагдах зардлын төсвийг хавсралтаар баталсугай.
3. Сумын Онцгой комисс, Шуурхай штаб, Мэргэжлийн ангийн бие бүрэлдэхүүнд шаардлагатай тоног төхөөрөмж худалдан авах, тохижилтын ажлын 5,000,000 (таван сая) төгрөгийг Орон нутгийн хөгжлийн сангаас зохих журмын дагуу анхан шатны баримт бичгийн бүрдлийг ханган зарцуулахыг нягтлан бодогч (Л.Цэнд-Аюуш)-д зөвшөөрсүгэй.
4. Захирамжид хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Отгонжаргал)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ч.СУГАРМАА

Сумын Засаг даргын 2024 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн 187 дугаар захирамжийн хавсралт



СУМЫН ОНЦГОЙ КОМИСС, ШУУРХАЙ ШТАБ,  
МЭРГЭЖЛИЙН АНГИЙН БИЕ БҮРЭЛДЭХҮҮНД ШААРДЛАГАТАЙ  
ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН ЖАГСААЛТ, ТОХИЖИЛТЫН  
МАТЕРИАЛЫН ТӨСӨВ

№	Зардлын нэр	Тоо хэмжээ	Нэгж үнэ	Нийт дүн
1	Үер усны далан босгох шуудай	200	1,500	300,000
2	Шуурхай штабын зураг	2	350,000	700,000
3	Цаг	2	25,000	50,000
4	Хүрз /төмөр/	10	20,000	200,000
5	Хүрз /цасны/	5	20,000	100,000
6	Троссон шүүр	10	20,000	200,000
7	Хээрийн газ	5	40,000	200,000
8	Гөвүүр	5	20,000	100,000
9	Усны помп	1	500,000	500,000
10	Үлээгч сэнс /галын/	1	900,000	900,000
11	Борооны цув	10	80,000	800,000
12	1 удаагийн комбинзон	20	6,000	120,000
13	Даавуун бээлий	100	1,000	100,000
14	Резинэн алгатай бээлий	100	800	80,000
15	Брезинтэн комбинзон	5	50,000	250,000
16	Маск /хорт хийн/	5	50,000	250,000
17	Баг /утааны/	3	50,000	150,000
	<b>НИЙТ ДҮН</b>			<b>5,000,000</b>